

## АГУУЛГА

|  |    |
|--|----|
| 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....   | 2  |
| 1.1. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ .....   | 2  |
| 1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ .....   | 6  |
| 1.3. ХОГ ХАЯГДАЛ .....   | 7  |
| 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ<br>БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ.....                 | 9  |
| 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ<br>ХҮРЭЭ.....                                  | 16 |
| 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....  | 18 |
| 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....   | 21 |
| 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....  | 22 |
| 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....  | 23 |
| 9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....   | 28 |
| 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....   | 31 |
| 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН<br>БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....               | 38 |
| 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ,<br>ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ..... | 39 |
| 13. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ .....  | 40 |

## 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

|                            |  |
|----------------------------|--|
| Төслийн нэр:               | Сорилтын шинжилгээний лаборатори                         |
| Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: | “Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК                        |
|                            | Улсын бүртгэлийн дугаар: 9011420015                      |
| Хаяг:                      | Регистрийн дугаар: 5723612                               |
|                            | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 хороо, үйлдвэр, 100/1 |
|                            | Утас: 91110207   |

“Ар Си Инспекшн” групп нь 2006 онд Голланд улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд ISO 9001:2008 стандартаар итгэмжлэгдсэн, хатуу бүтээгдэхүүн, металл, далайн хяналттай холбоотой үйл ажиллагаа явуулдаг хараат бус, хувийн өмчит, хөндлөнгийн хяналтын компани юм. “Ар Си Инспекшн” групп нь дээж бэлтгэл болон сорилт туршилтын ажлаараа London metall exchange /LME/-д бүртгэгдсэн цөөн Олон Улсын Хөндлөнгийн Хяналтын компаниудын нэг бөгөөд 40 гаруй улс орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг юм байна. Тус группын Монгол улс дахь салбар “Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК нь орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон эрдэс, металлын лаборатори болон хөндлөнгийн хяналтын лабораторийг 2013 онд байгуулсан. “Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК-ийн хөндлөнгийн хянагчид болон химичид нь эрдэс, металлын, тэр дундаа баяжмал, нүүрс, коксжсон материал болон түүн дотроос уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн болон Оюу-толгойн зэс, молибдений баяжмалын хяналтыг гүйцэтгэж байсан арвин туршлагатай хамт олноос бүрджээ.

“Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК нь доорх стандартуудаар итгэмжлэгдсэн:

- MNAS/ISO 17025:2007
- MNAS/ISO 17020:2013
- MNAS/ISO 17025:2018

Эрдсийн лаборатори нь 2016 оны 4 сард APLAC (Ази Номхон Далайн орнуудын Лаборатори Итгэмжлэлийн Холбоо)-аар магадлан итгэмжлэгдсэн бөгөөд MRA болон ILAC-ын хавсарсан лого тэмдэгийг сорилт туршилтийн үйлчилгээндээ ашиглах эрхийг авсан байна.

### 1.1. ТӨСЛИЙН ХУЧИН ЧАДАЛ

Эрдэс, металлын лаборатори нь олон улсын хяналтыг гүйцэтгэж байсан 5-30 жилийн туршлагатай инженерүүдийн багийг бүрдүүлж, нийт 17 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Сорилтын шинжилгээний лаборатори нь мэргэжлийн өндөр төвшинд бэлтгэгдсэн туршлагатай боловсон хүчин, Америк, Европын улсуудад үйлдвэрлэгдсэн лабораторийн дэлхийд тэргүүлэгч орчин үеийн технологи, олон улсын стандартын дагуух үйл ажиллагаагаараа дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх найдвартай үр дүнг гарган ажилладаг.


Эрдэс, төмөрлөгийн бус хүдэр, баяжмал, газрын ховор, өнгөт, үнэт, өндөр цэвэршилттэй металлуудын гэх мэт өргөн хүрээний үйлчилгээ үзүүлж байна. Салбар лабораториуд руу дээжийг илгээж шинжилснээр борлуулагч болон худалдан авагчдад найдвартай дүнг өгдөг ба үүнийг үндэслэн шинжилгээг гүйцэтгэх хугацааг тооцоолсон байдаг.

Хүснэгт 1. Үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт

| №  | Тоног төхөөрөмжийн нэр                   | Хийц /загвар/               | Ашиглалтанд оруулсан огноо | Хэмжих хязгаар, нарийвчлал                   |
|----|--|-----------------------------|----------------------------|--|
| 1  | Атом Шингээлтийн Спектрометр             | PinAAcle 500                | 2018.06                    | 185-900нм                                    |
| 2  | Атом Шингээлтийн Спектрометр             | AA-200                      | 2014.09                    | 185-900нм                                    |
| 3  | Спектрофотометр                          | AE-S80-2S                   | 2015.02                    | 190-1100nm                                   |
| 4  | Аналитик жин                             | Mettler-Toledo AG204        | 2014.05                    | max=210g, min=10mg, d=1mg                    |
| 5  | Аналитик жин                             | CAS Corporation, GAUY - 120 | 2019.05                    | max=210g, min=10mg, d=1mg                    |
| 6  | Микро аналитик жин                       | Mettler-Toledo MX5-029      | 2014.05                    | max=5.1g, d=1µg                              |
| 7  | Хагас микро аналитик жин                 | Mettler-Toledo AE260        | 2014.05                    | max=205g, min=50mg, d=1mg, e=1mg             |
| 8  | Техник жин                               | CAS Corporation, CBL-3200H  | 2017.10                    | max=3200, min=0.01g                          |
| 9  | Шатаах зуух                              | TC2044                      | 2014.05                    | 1100°C хүртэл                                |
| 10 | Шатаах зуух                              | TC2044                      | 2014.05                    | 1100°C хүртэл                                |
| 11 | Хатаах шүүгээ                            | UM500                       | 2014.05                    | 20-220°C хүртэл                              |
| 12 | pH метр                                  | edge® Dedicated pH Meter    | 2017.07                    | 1-16 ±0.1pH                                  |
| 13 | Ионметр                                  | Ion meter-930               | 2015.02                    | 0.00-20.00mg/L                               |
| 14 | Ус нэрэгч аппарат                        | Master-S                    | 2015.01                    | 1.0-4.0Kg/cm <sup>2</sup> , 120W, 220V, 50Hz |
| 15 | Усан ванн                                | DK-98-I                     | 2015.01                    | 5-100C                                       |
| 16 | Компрессор                               | 5KC37SN363ZX                | 2014.10                    | 220-240V, 50-60Hz, 2,2A                      |
| 17 | Цахилгаан халаагуур                      | CERAN 500                   | 2014.05                    | 50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz            |
| 18 | Цахилгаан халаагуур                      | CERAN 500                   | 2014.05                    | 50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz            |
| 19 | Цахилгаан халаагуур                      | CERAN 500                   | 2014.05                    | 50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz            |
| 20 | Цахилгаан халаагуур                      | CERAN 500                   | 2014.05                    | 50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz            |
| 21 | Цахилгаан халаагуур                      | CERAN 501                   | 2017.01                    | 50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz            |
| 22 | Цахилгаан халаагуур                      | CERAN 502                   | 2017.01                    | 50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz            |
| 23 | Индукцийн холбоостой плазмын спектрометр | Termo iCAP-7200             | 2017.06                    | 20-32A, 4000W, 200-240Volt, 50-60Hz          |
| 24 | Хайлуулалтын зуух                        | Biobase MF24-14T            | 2017.01                    | 1400°C хүртэл                                |
| 25 | Хайлуулалтын зуух                        | Biobase MF24-14T            | 2017.01                    | 1400°C хүртэл                                |
| 26 | Купеляцын зуух                           | Biobase M6-12T              | 2017.01                    | 1200°C хүртэл                                |
| 27 | Техник жин                               | CBX 12KH                    | 2017.01                    | max=12kg, min=1g, d=0.1g                     |
| 28 | Цахилгаан баригч UPS                     | France                      | 2019.04                    | 20kVA, 220/380V, 50Hz                        |
| 29 | Ультра соник цэвэрлэгч                   | WUC-D06H                    | 2019.04                    | 230V, 425W, 50-60Hz,                         |
| 30 | Соронзон хутгуур                         | MSH-20D                     | 2019.04                    | 230V, 660W, 50-60Hz,                         |
| 31 | Сэгсрэгч                                 |                             | 2019.09                    |  |



Зураг 1. Шатаах зуух ба татах шүүгээ



Зураг 2. Хатаах зуух ба атом шингээлтийн спектрометр



Зураг 3. ISO Lab сертификат бүхий шил сав болон спектрофотометр

**Химийн бодис:** “Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК-ийн сорилтын шинжилгээний лабораторийн агуулахад нь нийт 69 төрлийн 1.955 тонн химийн бодисыг хадгалж байх бөгөөд эдгээрээс шингэн бодис 10, хатуу байдалтай 59 бодис байна. Шинж чанарын хувьд авч үзвэл эрдэс болон органик хүчил 11, сүүрш шүлт 3, хүчлийн давс 32, металлын оксид 6, органик бодис 11, стандарт уусмал 1, индикатор буюу илрүүлэгч 5 төрлийн бодисууд байна.

Тус компани нь агуулахын 1 өрөөтэй бөгөөд нийт 22 м<sup>2</sup> талбайтай агуулахыг түрээслэн ашиглаж байна. Тус химийн бодисын агуулахад 2020.03.26-нд Мэргэжлийн хяналтын газар хяналт шалгалтын ажил гүйцэтгэж “Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын барилгад тавих ерөнхий шаардлага” MNS 6458:2014-ийн шаардлагыг хангаж байна хэмээн

дүгнэлт гаргасан байна. Уг хяналт шалгалтаар тус агуулахыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Лабораторит ашиглах химийн бодисыг хадгалах өрөө нь 22 м<sup>2</sup> талбайтай, стандартад заагдсаны дагуу тохижуулан, зориулалтын химийн бодис хадгалах аюулгүй байдлыг хангасан 4 ширхэг кабин, ацетилен, аргон хий хадгалах өрөөнд 2 ширхэг аюулгүй байдлын кабин тус тус байрлуулсан, механик агааржуулалтын систем болон хяналтын камер суурилуулсан 24 цагийн харуул хамгаалалттай.
- ✓ Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ MNS 5029:2011 стандартыг хангасан.
- ✓ Агуулахын байранд хийсэн физик хэмжилтээр гэрэлтүүлэг 250 люкс байна.
- ✓ Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэсээс олгосон №033/06 тоот галын аюулгүй байдлын дүгнэлттэй.
- ✓ Ажилтанд химийн бодистой харилцан ажиллах үеийн аюулгүй ажиллагааны хамгаалах хувцас, химийн бодис асгарсан тохиолдолд авах хариу арга хэмжээний иж бүрдэл зэргийг олгож, болзошгүй ослын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

Агуулахын ерөнхий байдлыг зураг 4-д үзүүлэв.



Зураг 4. Химийн бодисын агуулах

## 1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Төслийн талбай нь Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт, тус дүүргийн Засаг даргын 2017 оны 10 сарын 05-ны өдрийн А/756 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 178019/0055 дугаар бүхий 384м<sup>2</sup> газрыг контор, үйлдвэрлэл зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшихээр эрх авсан иргэн Ц. Бадмаанямбууд олгогдсон газар байна. Иргэн Ц. Бадмаанямбуугийн эзэмшил газарт баригдсан 4 давхар барилгад түүний “Өсөх түрүү” ХХК конторын болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэхээс гадна “Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК “Сорилтын шинжилгээний лаборатори”-ийн зориулалтаар 3-4 давхарыг өмчлөгч иргэнтэй түрээсийн гэрээ байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 2. Талбайн эргэлтийн цэг

| № | Өргөрөг |    |      | Уртраг |    |       |
|---|---------|----|------|--------|----|-------|
| 1 | 47      | 54 | 4.34 | 106    | 52 | 10.25 |
| 2 | 47      | 54 | 4.56 | 106    | 52 | 10.11 |
| 3 | 47      | 54 | 4.52 | 106    | 52 | 9.99  |
| 4 | 47      | 54 | 4.89 | 106    | 52 | 9.73  |
| 5 | 47      | 54 | 4.97 | 106    | 52 | 9.98  |
| 6 | 47      | 54 | 5.18 | 106    | 52 | 10.63 |
| 7 | 47      | 54 | 4.58 | 106    | 52 | 11    |



Зураг 5. Төслийн талбайн байрлал

### 1.3. ХОГ ХАЯГДАЛ

#### Хатуу хог хаягдал

**Ахуйн:** Лабораторийн ажиллагсдын ахуйн хатуу хог хаягдал гарахаар байна. Хатуу хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгж буюу Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан зайлуулж байна.

**Лабораторийн:** Уг лабораторийн хатуу хог хаягдлын эх үүсвэр нь агуулахад хадгалж буй химийн бодисын сав баглаа боодлоос гарах хог хаягдал байна.

Харин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний явцад ашиглалтаас бүрмөсөн гарсан сэлбэг хэрэгсэл зэрэг зүйлс гарч болох юм. Тэдгээрийг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдэд тушаах, дахин ашиглах зэрэг арга хэмжээ авна.

Төслийн ажиллах хүчин чадлыг үндэслэн Засгийн газрын 2017 оны 12-р сарын 25-ны өдрийн А/368-р тушаалын хавсралт “ХОГ ХАЯГДЛЫН НОРМАТИВ ХЭМЖЭЭГ ТОГТООХ АРГАЧЛАЛ”-ын дагуу тооцвол хоногт дунджаар 25.5 кг, сард 765 кг, жилд 9.18 тн орчим хог гарахаар байна.

Иймд ахуйн гаралтай, дахин ашиглах боломжтой хатуу хог хаягдлыг ангилж ялгасан, шаардлага хангасан хогийн цэгт төвлөрүүлэн зохих журмын дагуу зайлуулж хэвшсэн байна.

#### Шингэн хаягдал


**Төслийн ус хэрэглээ:** Усны нийт хэрэглээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301-р тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцож хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Шаардлагатай усны хэмжээ

| №    | Ус хэрэглээний төрөл | Тоо хэмжээ, хүн/хон | Норм,         | Хоногийн хэрэглээ, л | Сарын хэрэглээ, м <sup>3</sup> | Жилийн хэрэглээ, м <sup>3</sup> |
|------|----------------------|---------------------|---------------|----------------------|--------------------------------|---------------------------------|
| 1    | Ажилтан              | 17                  | 80 л/хон      | 1360                 | 40.8                           | 489.6                           |
| 2    | Лаборатори           | 17                  | 300 л/ажилтан | 5100                 | 153                            | 1836                            |
| Нийт |                      |                     |               | 6460                 | 193.8                          | 2325.6                          |

Энэхүү тооцооноос харахад төслийн үйл ажиллагаанд нийтдээ жилд **2325.6м<sup>3</sup>** ус шаардлагатай байна.

Төслөөс лабораторын шинжилгээнээс гарах бохир ус болон ахуйн гаралтай шингэн хаягдал гарна. Төслийн үйл ажиллагааны үед хоногт дунджаар 6.46м<sup>3</sup>, жилд 2325.6 м<sup>3</sup> бохир ус гарахаар байна. УСУГ-тай “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ” байгуулсан гэрээг хавсаргав.



Зураг 6. Ажилчдын ариун цэврийн байгууламж



## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Судалгааны талбай орчим нь Туул голын 2-р дэнжид хамаарах бөгөөд газрын гадаргуу нь тэгш тогтоцтой өндрийн зөрүү 0.5м орчим бөгөөд голын хөндий дагасан хуучин салаа, хонхор, төлөвлөлт, хяналтгүй ашиглаж байсан хайрганы карьерын олборлолт зэрэгтэй холбогдон үүссэн бичил рельеф элбэгтэй талбай байна.

**Геоморфологи, гидрогеологийн нөхцөл:** Судалгааны раойнд дээд-орчин үеийн дөрөвдөгчийн настай, аллювийн гаралтай (alQIII-IV) элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс 6.0 метр хүртэл гүнд жигд тархсан. Сонгосон талбай нь геоморфологийн хувьд Туул голын хөндийн хуримтлалын гадаргуу болно.

**Уур амьсгал:** Судалгааны объект нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршино. Цаг уурын Буянт-Ухаа өртөө төслийн талбайгаас баруун урд зүгт оршино. Төслийн район нь жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзлэл ихтэй, хур тунадас бага, үүлшил, агаарын чийгшил багатай эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг.

Агаарын дулаан хүйтний горим: Төслийн районд агаарын температурын жилийн агууриг нь сарын дундаж температураар  $41.3^{\circ}\text{C}$ , хамгийн их, бага температурын дунджаар  $55.1^{\circ}\text{C}$  буюу жилийн доторхи дулаан хүйтний хэлбэлзэл ихээхэн байдаг байна. Олон жилийн ажиглалтын цуваатай Буянт Ухаад үнэмлэхүй хамгийн бага температур 1954 оны 12 дугаар сарын 30-нд - $49.0^{\circ}\text{C}$  ажиглагдсан бөгөөд сүүлийн жилүүдийн мэдээгээр 2001 оны 1 дүгээр сарын 9-нд - $46.7^{\circ}\text{C}$  хүрсэн байна. Харин үнэмлэхүй өндөр температур “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт. БНБД. 2.01.01-93”-д тэмдэглэснээр 1939 оны 7 дугаар сарын 15-нд  $38.6^{\circ}\text{C}$  гэж тэмдэглэсэн атал сүүлийн үеийн ажиглалтаар 2005 оны 7 дугаар сарын 15-нд  $39.5^{\circ}\text{C}$  хүрсэн байна. Өөрөөр хэлбэл хамгийн их, бага температураар агаарын температурын агууриг нь  $88.5^{\circ}\text{C}$  болсон байна.

Нарны цацраг: Нар гийгүүлэх цагийн сарын нийлбэр нарны өндрөөс хамаарч 12 дугаар сард хамгийн бага-164 цаг, 5 дугаар сард хамгийн их -288 цаг байна. Энэ үзүүлэлт нарны өндөр хамгийн их байдаг 6 дугаар сард гарахгүй байгаа нь 6, 7 дугаар сард манай оронд үүлшил ихсэхтэй холбоотой юм.

Нийлбэр цацрагийн жилийн нийт хэмжээ  $1276.7\text{кВт цаг/м}^2$ -аас  $1379.8\text{ кВт цаг/м}^2$  байх ба жилийн явц нь шууд цацрагийнхтай ижил өвөл бага, зун их байдаг.

Хур тунадас: Жилийн нийлбэр хур тунадас Буянт-Ухаа өртөөнд 262мм, Улаанбаатар өртөөнд 266.2мм, Амгалан өртөөнд 271.4 орчим мм хур тунадас унах бөгөөд түүний 92.0 хувь нь жилийн дулаан улиралд /4-9 дүгээр сарын хооронд/ орно. Жилийн хүйтэн улиралд хур тунадас түн бага унана. Жилдээ дунджаар 21.1 өдөр аянга цахилгаантай байдаг, хамгийн олондоо 35 өдөр хүрч байсан аж. Аянгатай бороо жилдээ дунджаар 28.1 цаг үргэлжлэх бөгөөд 7 дугаар сард хамгийн удаан үргэлжилдэг байна. Аянгатай борооны 56.6 хувь нь 30 минутаас 2 цаг орчим үргэлжилнэ. Салхи шуурганы горим: Төслийн районд жилд дунджаар 13.9 өдөр шороон шуурга, 4.2 өдөр явган шороон шуурга шуурдаг. Шороон шуурганы 38.4% нь өдрийн 12-15 цагт, 16.7% нь 15-18 цагт, 22.8% нь 9-12цагт тохиолдоно. 0.0-6.0 цагийн хооронд шороо шуурах нь ховор байдаг байна.

Жилийн дундаж байдлаар зүүн өмнөд ба өмнөдийн салхи зонхилох боловч тухайн газар орны хотгор гүдгэрээс хамаарч газар бүр өөр өөр.

**Агаарын чанар:** Төслийн талбай нь байршил нь БОНХЯ-ны сайд, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчилсэн ангиллаар 4-р бүсэд хамаарна. Төслийн агаарын бохирдлын гол эх үүсвэр нь ажилчдын автомашинуудын хөдөлгөөний үед үүсэх тоосжилт болон хийн бохирдол байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдол 10 дугаар сараас эхлэн дараа оны 3 дугаар сар хүртэл ихэсдэг байдал ажиглагдаж, цаг агаарын тааламжгүй нөхцөл /температурын инверси, хүйтэн өвөл/ бүрэлддэгтэй холбоотой. Хүйтний улирлын агаарын бохирдлын эх үүсвэрийн 80% нь гэр хороолол болон усан халаалтын зуухнаас, 10 орчим хувь нь авто тээврийн хэрэгслээс, 6 орчим хувь нь дулааны цахилгаан станцаас, 4 орчим хувь нь хог шороо, хөрсний бохирдлоос үүсдэг байна.

Байгаль орчны төлөв байдлын судалгааны хүрээнд 5 байршил сонгож  $PM_{10}$  болон  $PM_{2.5}$  үзүүлэлтийг зориулалтын гар багажаар хэмжсэн. Хэмжилтийн үр дүнгээс харахад Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 стандартаас давсан үзүүлэлт илрээгүй байна.

**Физик бохирдол:** Физик бохирдолд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй шуугиан, доргио, цахилгаан соронзон орон, радио идэвхит бодисын ионжуулах цацрал, дулааны цацрал, хэт ягаан цацрал багтдаг. Төслийн талбайд автомашины хөдөлгөөн, хот тосгон, үйлдвэрийн үйл ажиллагааны хөлд нэрвэгдэж физик элэгдэлд нилээн орсон тул байгалийн унаган төрхөө бүрэн алдсан.

Лабораторийн ажилчдын автомашинаас гарах хийн хаягдал нь агаарын бохирдлын тухайлсан эх үүсвэрт орж байна.

Судалгааны ажлын явцад төслийн талбайд хэмжсэн дуу чимээний хэмжилтээс харахад харьцангуй тааламжтай орчин байна.

**Гадаргын ус:** Төслийн талбай нь Монгол орны гадаргын усны сүлжээний томоохон төлөөлөл Түүл голын сав газрын урсац дамжин өнгөрөх хэсэг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт оршино.

Судалгааны талбайн ус зүйн сүлжээг бүрдүүлэгч Түүл гол, түүний цутгал голууд Хойд Мөсөн далайн ай савд багтана. Түүл гол Хан Хэнтий нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авч 800-1000м өндөр уулсын хоорондуур урсаж, Орхон голын баруун талын хамгийн том цутгал болж, Орхон голд цутгадаг. Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галтай, Сарьдагийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол горхи Түүлд цутгана.

Түүл голын усны тэжээлийн онцлог нь түүний урсцын харьцангуй бага хувийг газрын доорх ус ба улирлын цасны ус эзэлдэгт оршино. Голын урсцын 25 хувийг ул хөрсний ус, 6 хувийг хайлсан цасны ус, 69 хувийг хур борооны ус эзэлнэ. Үүнээс үзэхэд Түүл гол усны горимын хэв шинжээрээ хаврын шар усны болон зуны хур борооны үерийн горимтой голд хамаарна. Голын урсцыг бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл нь зун, намрын хур бороо учраас усны төвшин дулааны улиралд ихээхэн тогтворгүй байдаг.

2019 оны 3-р сараас 2020 оны 3-р сар хүртэлх Түүл голын шинжилгээний дүнгээс харахад Улаанбаатар хотоос дээш хэсэгт Түүл голын усны ууссан хүчилтөрөгчийн горим хэвийн, голын ус бохирдолгүй, цэвэр байна. Улаанбаатар хотын хаягдал бохир ус цэвэрлэх төв байгууламжаас цэвэршүүлэгдээд гарч буй цэвэршүүлсэн бохир ус нийлснээс доош буюу Сонгиноос Алтанбулаг хүртэлх хэсэгт голын усны ууссан хүчилтөрөгчийн горим алдагдаж **онцгой их бохирдлын төвшинд** хүрсэн ба усны бохирдол ихсэж, усны чанарын стандарт MNS4586-98 дахь хүлцэх

агууламжаас давж, **их бохирдол, онцгой их бохирдлын төвшинд** хүрч агууламж, бохирдолтой үзүүлэлтийн тоо нэмэгдсэн байна.

Нийслэлийн нутаг дэвсгэр дэх усны сан бүхийг газарт байгаа гадаргын усны тооллогын 2018 оны мэдээгээр нийт гол, горхи 48, үүнээс байнгын урсацтай 22, түр урсацтай 25, ширгэсэн 1, булаг шанд 120, үүнээс байнгын урсацтай 87, түр урсацтай 27, ширгэсэн 9 байна. Эдгээрээс 30 булаг хашиж хамгаалсан бол 37-ыг хашиж хамгаалах шаардлагатай байгаа. Рашаан нийт 14, байнгын урсацтай 12, түр урсацтай 2 байгаагаас хашиж хамгаалсан 7 бол, хашиж хамгаалах шаардлагатай 1 байна. Нүүр цөөрөм нийт 8, байнгын урсацтай 7, ширгэсэн 1, үүний 2-ыг хашиж хамгаалжээ.

**Газрын доорх ус:** Энэ талбайн гидрогеологийн нөхцөлийн хувьд Туул голын хөндийн дөрөвдөгчийн настай аллювийн сэвсгэр хурдсанд агуулагдаж байгаа газрын доорх усны хүримтлалыг авч ашиглаж байгаа бөгөөд энэ ус агуулагч хурдасны зузаан дунджаар 45-50м байдаг. Энэ устай үе нь Туул голын устай гидравлик холбоотой ба газрын доорх усны тэжээлийн гачиг үед Туул голын ус нь газрын доорх усаа тэжээж, харин газрын доорх усны тэжээлийн оргил үед Туул голын усаа тэжээдэг харилцан уялдаатай оршдог.

**Усны нөөц:** Судалгаанд хамрагдаж байгаа талбайтай ойрхон бараг давхцаад ТЭЦ-3-ийн техникийн усны эх үүсвэрийн хурднууд байрлаж байгаа бөгөөд 1977-1979 онуудад хийгдсэн ПНИИС институтын газрын доорх усны нөөцийн судалгааны ажлын хүрээнд ТЭЦ-3-ын техникийн усны эх үүсвэрийн нөөцийг тооцож (13 цооногт) А-зэрэглэлээр 41400м<sup>3</sup>/хон, (3 цооногт) С<sub>2</sub> зэрэглэлээр 3900м<sup>3</sup>/хон гэж нийт А+С<sub>2</sub> 45300м<sup>3</sup>/хон нөөцтэй гэж тооцож гаргасан байдаг.

**Хөрсөн бүрхэвч:** “Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн судалгааны талбай нь хөрс-газарзүйн мұжлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн төвийн хэсгийн 38-р тойргийн нутагт хамаарна (Монгол Улсын Үндэсний Атлас, 2009).

Хотжилт, газар ашиглалттай холбоотойгоор төсөл хэрэгжиж буй талбайн хөрсний өнгөн хэсгийн үржил шимт үе давхарга бүрэн устаж алга болсон байна.

**Аллювийн ширэгт хөрс.** Аллювийн ширэгт хөрс нь голын гольдрол орчмын хөвөө татмын төвгөрдүү хэсгээр тархах бөгөөд түүний чийгшилтэд газрын доорхи усны нөлөө бага, үерийн ус ч төдий л дэм өгч чадахгүй учраас агаарын хур тунадас голлох үүрэгтэй байна. Газрын доорх ус зөвхөн 7-сарын сүүлч, 8-р сард богинохон хугацаанд үйлчлэх тул ургамлын өсөлт хөгжилтөнд төдийлөн нөлөөлж чаддаггүй байна. Чийгийн горимын судалгаанаас үзэхэд аллювийн ширэгт хөрс ус чийгээр нилээн дутмаг, чийгийн хэмжээ нь зуны турш ургамал гундах чийгээс капилляр сүвийн холбоос тасрах үеийн чийг хүртэл, хамгийн их гигроскоп чийгээс ургамал гундах чийг хүртэл заагаас хэтрэхгүй бөгөөд зарим зун хур борооны хоорондох хугацаанд хуурайших явдал байн байн тохиолдоно. Ургамлын үндсээр шигүү торлогдсон, боровтор саарал өнгөтэй, бутрамтгай бөөмөрхөг бүтэцтэй, ихэнхдээ хуурай байдаг ба аллювийн элс-хайргархаг хурдас дээр тогтворжсон, их төлөв элс-элсэнцэр бүрэлдхүүнтэй байдаг. Аллювийн ширэгт хөрсний үе давхарга нимгэн, элсэн хурдасны судалтсан үе олонтой, голдуу элс-элсэнцэр бүрэлдхүүнтэй, ширэгт ялзмагийн давхаргаас бусад үе давхаргууд морфологийн хувьд бүдэг илэрсэн зэрэг нь энэ хөрсний гол онцлог юм. Ширхэгийн бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар, элсэнцэр, элсэрхэг хөрс голлоно. Алаг өвс, үетэн, ширэг улалж бүхий нугархаг хээрийн бүлгэмдэл зонхилох бөгөөд ургамлын бүрхэц нь 50-70% орчим, заримдаа түүнээс ч сийрэг байна. Аллювийн ширэгт хөрсний хэв шинжийг дэд хэв шинжүүдэд ялгах шаардлага одоогоор байхгүй бөгөөд хөрс нь өөрийн хими физик шинж чанар болон бүрэлдэн тогтсон газарзүйн онцлог

зэргээс шалтгаалан хэд хэдэн төрөлд хуваагддаг. Үүнд: ердийн, үелсэн тогтоцтой, хээршмэл гэсэн 3 төрөлд хувааж болох байна.

**Техносол хөрс.** Автозамын орчимд болон барилгажсан төвүүдэд хөрсөн бүрхэвч эвдрэлд өртөж, техноген нөлөөллийн улмаас хөрс анхдагч шинж чанараа алдсан байна. Хот суурин газрын нутаг дэвсгэр нь техноген нөлөөлөлд хүчтэй өртөн, үржил шимт давхарга зулгаран арилж, хөрс үүсгэгч эх чулуулаг ил гарсан байдаг. Мөн антропоген нөлөөллийн улмаас хөрсний өнгөн хэсэгт хучаас үе үүсдэг. Хот суурин газрын барилгажсан талбайд хөрсийг хусан зайлуулж, шинээр үржил шимт хөрсөөр хучин ногоон байгууламж бүхий урбаназём төрлийн хөрс үүсдэг бол хотын захын гэр хороолол, зуслан зэрэг газар ашиглалтын төрлүүдэд хүний үйл ажиллагааны улмаас үржил шимт давхарга устсан, хучаас хурдсаар дарагдсан, үе давхарга механикаар холилдсон зэрэг хэв шинжийг ялган үздэг.

Хүнд металлын агууламжийг талбайгаас 1 цэгийн өнгөн хөрснөөс авсан дээжинд тодорхойлуулсан. Монгол улсын стандарт Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 5850:2019)-ийн стандартын хүлцэх агууламжийн үзүүлэлттэй харьцуулахад шинжлүүлсэн хүнд металлуудын хувьд давсан үзүүлэлт байхгүй буюу ямар нэг бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.

**Ургамлан бүрхэвч:** Төслийн талбай орчим нь Хэнтийн хэв шинжид багтах алаг өвс-бутлаг үетэн, бутлаг алаг өвст хээрийн, алаг өвс-улалж-биелэг өвст-үетэн зэрэг олон төрөл зүйлийн баялаг ургамлын нөмрөгтэй байсан. Талбайд барилга байгууламж, зам, машин техникийн хөдөлгөөний улмаас байгалийн ургамлын нөмрөг үгүй болсон. Эзэмшил талбайн хэмжээгээр барилгажсан хатуу хучилттай, хашааны урд хэсгээр захалсан нарийн зурвас багахан газарт техносол хөрс тархсан ба тэр зурваст шарилж, лууль зонхилсон хөрс, байгалийн зохисгүй нөхцөлд ургадаг хог ургамлууд зонхилж байна. Бэлчээрийн нөлөөгүй.

**Тусгай хамгаалалттай газар нутаг:** Төслийн нутаг дэвсгэрт хамгийн ойр орших улсын тусгай хамгаалалттай газар бол Богдхан уулын дархан цаазат газар байна. Төслийн талбайгаас Богдхан уулын дархан цаазат газрын хамгийн ойрхон хил нь урд зүгд 1.6 км зайтай.

Богдхан уул нь манай орны төдийгүй дэлхийн ууган дархан газар юм. XII-XIII зууны үед Хэрэйд аймгийн Ван хаан Тоорил Богдхан уулыг тахиж, Туулын хар шугуйгаар нутаглаж байхдаа өөрийн эрх хэмжээнд онголон дархалсан түүхтэй.

Өлзийт хааны тэргүүн он буюу 1294 онд гаргасан Монголын их Юань улсын хууль цаазны бичгийн 398 дугаар бүлэгт “Богдхан уул, Отгонтэнгэр, Хан Хэнтий, Алтайн нүсэр даваа” байгалийн үзэсгэлэнт газруудыг дархан цаазтай болгож байжээ.

1778 онд тэр үеийн Монголын тэргүүний сэхээтний нэг хүрээ сайд Юндэндоржийн санаачлагаар Богдхан уулыг албан ёсоор дархалж хамгаалалтад авсан байна. Сайд Юндэндорж Богдхан уулыг дархалуулахаар өргөсөн бичигтээ “Дөрвөн аймгийн чуулган нийлэх газар бөгөөд хормойд нь шар, хар олон түмэн хуран суух нь хүрээ оршихын дээр ан, амьтад, ой модоор элбэг баян, олон түмэндээ магтагдсан, холын жуулчдын анхаарлыг татсан энэ үзэсгэлэнт сайхан уулыг эцэг өвгөдөөс дархалж ирсэн учир үүнийг хуучин ёсоор тахин онгон дархан цаазтай болгож өгөхийг хичээнгүйлэн гүйсугай” хэмээн хүссэний дагуу Тэнгэрийг тэтгэсний 43 дугаар оны 9 дүгээр сарын 24-ний өдөр хааны зарлигаар дахин дархалсан байна.

**Түүх соёл, археологийн дурсгалт зүйлс:** Тус лаборатори болон ойр орчмын бүс нь үйлдвэрийн зориулалтаар олон жилийн туршид ашиглагдаж ирсэн бөгөөд одоог хүртэл хийсэн археологийн судалгаанаас үзвэл түүхийг олдвор, дурсгалт зүйл газар үгүй болно. Цаашид үйл ажиллагааны

явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийн үнэлгээг нэгтгэн доорх хүснэгтээр харууллаа.

### 3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн “Сорилтын шинжилгээний лаборатори” төслийн үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, газрын доорх ус зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн, хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах, агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах, хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг тухай бүрд нь хэрэгжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулбал эерэг тал нь илүү болох юм.

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь ажиллагсдын ажлын байрны орчин (гэрэлтүүлэг, чимээ шуугиан, чийгшилт, тоосжилт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг), болгоомжгүй байдлаас гал түймэр гарах, химийн бодис алдах асгарах зэрэг асуудал байна.

Төслийн агаарын бохирдлын гол эх үүсвэр нь лабораторийн шинжилгээний үйл явцаас үүсэх хийнүүд болон ажилчдын автомашинуудын хөдөлгөөний үед үүсэх тоосжилт болон хийн бохирдол байна.

Хүснэгт 4. Байгаль орчны болзошгүй нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэгтгэл

| Нөлөөллийн төрөл   | Эрчим | Үргэлжлэх хугацаа | Хамрах хүрээ | Магадлал | Нийт оноо | Онооны эзлэх хувь % | Нөлөөл-лийн зэрэг |
|--|-------|-------------------|--------------|----------|-----------|---------------------|-------------------|
| <b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>   |       |                   |              |          |           |                     |                   |
| Газарт үзүүлэх нөлөөлөл  | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Агаарт үзүүлэх нөлөөлөл  | -4    | -4                | -1           | -5       | -14       | 56%                 | M                 |
| Усан орчинд үзүүлэх нөлөөлөл   | -5    | -3                | -1           | -2       | -11       | 44%                 | M                 |
| Хөрс, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нөлөөлөл   | -1    | -3                | -3           | -2       | -9        | 36%                 | M                 |
| Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл   | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл   | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| <b>Дундаж</b>  |       |                   |              |          |           | <b>-45.3%</b>       | <b>M</b>          |
| <b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>   |       |                   |              |          |           |                     |                   |
| Газрын гадаргын нөөц баялаг  | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Бэлчээр, тэжээлийн байдал  | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Эрдэс түүхий эдийн нөөц  | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| <b>Дундаж</b>  |       |                   |              |          |           | <b>-</b>            |                   |
| <b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>   |       |                   |              |          |           |                     |                   |
| Газрын доорх усны нөөц, чанар  | -4    | -3                | -2           | -3       | -12       | -48%                | M                 |
| Хөрсний бохирдол   | -4    | -5                | -1           | -2       | -12       | -48%                | M                 |
| Дуу чимээ, шуугианы нөлөөлөл   | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх   | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Уул уурхайн үйл ажиллагаанд нөлөөлөх   | +6    | +5                | +1           | +3       | +14       | +56%                | +                 |
| <b>Дундаж</b>  |       |                   |              |          |           | <b>-48%</b>         | <b>M</b>          |
| <b>4. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл,соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл</b> |       |                   |              |          |           |                     |                   |
| Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх   | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх   | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт  | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх  | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| Археологи, палеонтологийн олдворт  | 0     | 0                 | 0            | 0        | 0         | -                   |                   |
| <b>Дундаж</b>  |       |                   |              |          |           | <b>-</b>            |                   |
| <b>5. Бусад нөлөөлөл</b>   |       |                   |              |          |           |                     |                   |
| Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга   | -6    | -1                | -2           | -2       | -11       | -44%                | M                 |

| Нөлөөллийн төрөл                 | Эрчим | Үргэлжлэх хугацаа | Хамрах хүрээ | Магадлал | Нийт оноо | Онооны эзлэх хувь % | Нөлөөл-лийн зэрэг |
|----------------------------------|-------|-------------------|--------------|----------|-----------|---------------------|-------------------|
| Осол аваар, халдварт өвчин гарах | -6    | -1                | -3           | -2       | -12       | -48%                | М                 |
| <b>Дундаж</b>                    |       |                   |              |          |           | <b>-46%</b>         | <b>М</b>          |
| <b>Үр дүн /ерөнхий дундаж/</b>   |       |                   |              |          |           | <b>-46.4%</b>       | <b>М</b>          |

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийн үнэлгээг нэгтгэн үзвэл - 46.4% хувь буюу дунд зэргийн нөлөөлөлтэй байна. Энэхүү төсөл цаашид БОМТ-г боловсруулан болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

#### 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

##### Үндсэн зорилго, зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Сорилтын шинжилгээний лаборатори” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тодорхойлох үндсэн зорилготой.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхийн хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
2. БОМТ-ний хэрэгжилтийг компанийн удирдлага өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр лабораторийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.

##### БОМТ-ний гол зарчим

Төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү 5 жилийн БОМТ-нд тулгуурласан тухайн жил бүрийн БОМТ-ийг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тайлагнан ажиллана.

Тухайн жилийн БОМТ-г боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаа нь БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдөр баталсан А-618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтална.

Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9-р зүйлийн 8-р заалт: “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

##### Хамрах хүрээ

БОМТ нь “Сорилтын шинжилгээний лаборатори” төслийн үйл ажиллагааны хэмжээнд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын дагуу хэрэгжих бөгөөд БОННУ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон байгаа.

“Сорилтын шинжилгээний лаборатори” төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий энэ төлөвлөгөөнд БОННУ-ний



тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрэн дэх бүхий л асуудлыг хамрахад БОМТ нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ),
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө.

Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө;
- ✓ Лабораторийн орчны тохижилт, өргөтгөлийн дараах нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө;
- ✓ Лаборатори орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;
- ✓ Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежмент;
- ✓ Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежмент;
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ;
- ✓ Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт;
- ✓ БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэхарга хэмжээний төлөвлөлт;

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Сорилтын шинжилгээний лаборатори” төслийн БОННУ-ний явцад тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх үйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| №                       | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд  | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ                             | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг  |
|-------------------------|---|--|---|-------------|-------------------------|------------|----------------------|------------------------------|--|
| <b>1. Агаарын чанар</b> |   |  |   |             |                         |            |                      |                              |  |
| 1.                      | Химийн бодис хадгалах өрөө болон шинжилгээ судалгаа, дээжийн задаргаа хийх өрөөнүүдийн агааржуулалтын ажиллагаа доголдсоноос бодис уурших, халах, тэлэх нөхцөл үүсэж болзошгүй. | Агааржуулалтын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн ажиллагааг байнга анхаарч, засвар үйлчилгээ, шинэчлэлийг тухай бүр хийж байх               | Задаргааны, шинжилгээний болон химийн бодис хадгалах өрөө | -           | 400,000                 | 1          | 400.0                | Тогтмол                      | - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) |
| 2                       | Бодисууд уурших, исэлдэн-ангижрах урвалд орох, агаар орчинд тархах зэргээр агаарын чанарыг өөрчлөх  | Химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд хадгалах |   |             |                         |            |                      |                              | -  |
| 3                       | Болзошгүй аюул, ослын үед хорт хий ялгарч агаарын чанарт нөлөөлөх   | Химийн бодисын агуулах болон лабораторийн үндсэн барилга байгууламж нь MNS 6458:2014 стандартын  |   |             |                         |            |                      |                              |  |

| №                        | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд  | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ  | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг)  | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж  | Баримтлах эрх зүйн баримт бичиг   |
|--------------------------|---|--|--|-------------|--|------------|----------------------|---|---|
|                          |   | шаардлагыг хангасан дулааны тусгаарлалт, агааржуулалт, салхивч, гэрэлтүүлэгтэй байх  |  |             |  |            |                      |   |   |
| <b>2. Усан орчин</b>     |   |  |  |             |  |            |                      |   |   |
| 1                        | Лабораторийн химийн бодис агуулсан шингэн хаягдлыг төвлөрсөн шугам сүлжээгээр зайлуулснаас усны чанарт сөрөг нөлөө үзүүлэх  | Химийн бодис агуулсан шингэн хаягдлыг төв шугамд нийлүүлэлгүй, устгах эрх бүхий байгууллагад өгч устгуулах   | Лабораторийн хаягдал ус  | -           | Хог хаягдлын менежментийн зардалд багтсан.   |            |                      | Байнгын   | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, 14.2.1, 14.2.2, 14.2.4-р зүйл заалт |
| 2                        | Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь ахуйн хог хаягдал, лабораторийн хаягдал угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах | Ахуйн хог хаягдал болон лабораторийн шингэн хаягдал, химийн бодисын сав баглаа боодлын хадгалалтад тогтмол хяналт тавих асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах | Химийн бодисын сав баглаа боодол хадгалах цэг<br>Хогийн цэгийн орчим<br>Лабораторийн шингэн хаягдал хадгалах агуулах |             | Үйл ажиллагааны дотоод зардалд   |            |                      | Тухайн бэлтгэсэн хэрэгсэл, материал дуусах болон ашиглалтаас гарах бүрд | Усны тухай хууль, 22.1, 23.1, 24.1 зүйл заалт   |
| <b>3. Хөрсөн бүрхэвч</b> |   |  |  |             |  |            |                      |   |   |
| 1                        | Химийн бодис тээвэрлэх, зөөх, хадгалах үед санамсар болгоомжгүй байдлаар химийн бодис их хэмжээгээр асгарсан  | -Бодис их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах<br>-Асгарсан тохиолдолд MSDS-д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах   | Химийн бодис тээвэрлэх, зөөх, хадгалах үйл ажиллагааны үед   |             | Төслийн үйл ажиллагааны жил бүрийн үрсгал зардалд тусгаж ажиллах тул зардал тусгайлан төлөвлөөгүй болно. |            |                      | Байнга  | MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”                              |

| №  | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ        | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|--|--------------------------------------|---|--------------------------------------|-------------|-------------------------|------------|----------------------|------------------------------|---------------------------------|
|  | тохиолдолд хөрс бохирдоно.           | -Хүнсний сод, элс, шороо, вермикулитыг бэлэн байлгах  |                                      |             |                         |            |                      |                              |                                 |
| 2  | Хөрсний болзошгүй бохирдол           | Ахуйн хог хаягдлыг ангилан хадгалах, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж байх                     | Хогийн цэгийн орчим                  |             |                         |            |                      |                              |                                 |
| <b>БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг</b> |  |   |  |                                |                          |                  | -                              |

### 13. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Лабораторийн үйл ажиллагаанд БОМТ-г хэрэгжүүлэхэд 2024 онд нийт 9,069.0 мянган төгрөгийн зардал тооцогдож байна.

#### Хүснэгт 16. БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал

| №                  | БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц                                   | Нийт тооцсон зардал, мян.төг | Нийт дүнд эзлэх хувь |
|--------------------|--|------------------------------|----------------------|
| 1                  | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ                             | 400.0                        | 4.4                  |
| 2                  | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө                      | 1500.0                       | 16.5                 |
| 3                  | Түүх соёлын өвийг хамгаалах  | -                            | -                    |
| 4                  | Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө                                | -                            | -                    |
| 5                  | Хог хаягдлын менежментийг зохион байгуулах                         | 6,020.0                      | 66.4                 |
| 6                  | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр                                 | 649.0                        | 7.2                  |
| 7                  | Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ                         | 500.0                        | 5.5                  |
| 8                  | БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх | -                            | -                    |
| <b>Нийт зардал</b> |  | <b>9,069.0</b>               | <b>100</b>           |



БАТЛАВ  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН  
ДАРГА Ц ТӨРХҮҮ



БАТЛАВ

ЭЗЭН *Ц.Бадмаанямбуу* Ц.БАДМААНЯМБУУ

**ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫГ “ЦЭВЭР УСААР ХАНГАХ,  
ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ” АЖ АХУЙН ГЭРЭЭ**

2020 оны 05 сарын 29 өдөр

Хэрэглэгчийн бүртгэл № 26049800

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Нэг талаас УСУГ түүнийг төлөөлж А/41 тоот тушаалыг үндэслэн гэрээний инженер албан тушаалтай Ө.ДАШНЯМ цаашид “хангагч” гэх, нөгөө талаас ЭЗЭН Ц.БАДМААНЯМБУУ “хэрэглэгч” гэх нар нь Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13 дугаар зүйл болон бусад холбогдох хуулийг удирдлага болгон 2020/05/29 -ны өдрөөс эхлэн дор дурьдсан нөхцлийг биелүүлж ажиллахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулж байна.

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааг зохицуулах дүрэм нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

**ХОЁР. НИЙЛҮҮЛЭХ ЦЭВЭР УС БОЛОН ТАТАН ЗАЙЛУУЛАХ БОХИР  
УСНЫ ХЭМЖЭЭ, ЧАНАР, НАЙРЛАГА, ТӨЛБӨР, ТООЦОО ХИЙХ**

- 2.1 Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр ус болон хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан усны тоолуураар хэмжих ба хэрэглээг тоолуурын заалтыг үндэслэн тооцно. Тоолуурын заалтаар гарсан хэрэглэсэн цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон бусад түүнтэй холбогдох төлбөрийг “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн баталсан усны үйлчилгээний тарифыг мөрдлөг болгоно;
- 2.2 Хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг тухайн хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээтэй адилаар тооцно;
- 2.3 Хэрэглэгчийн хэрэглээнээс гарч байгаа бохир усны найрлага нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн 50 дугаар тогтоолоор батлагдсан MNS 6561:2015 “Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны найрлага”-ын зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд Монгол улсын Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын дагуу ус бохирдуулсны төлбөрийн хэмжээгээр нэмэлт төлбөр төлнө
- 2.4 Гуравдугаар циклд хамрагдаж байгаа хэрэглэгчийн усны тоолуурын заалтыг сар бүрийн 14-өөс 20-ны хооронд авах бөгөөд хангагч, хэрэглэгчийн төлөөлөгч хамтран хяналтын картанд харилцан гарын үсэг зурж, баталгаажуулсан байна;
- 2.5 Хангагч нь гуравдугаар циклийн хэрэглэгчийн усны төлбөрийн нэхэмжлэл болон тооцооны хуудсыг сар бүрийн 22-ны өдөр [www.eus.mn](http://www.eus.mn) сайтад байршуулж, төлбөрийн нэхэмжлэл гарсан тухай мессежийг хэрэглэгчийн

- гэрээнд тэмдэглэгдсэн утасны дугаарт илгээнэ;
- 2.6 Хангагч нь сар бүрийн 24-25-ны дотор хэрэглэгчийн төлбөр төлөх эцсийн хугацааг мессежээр сануулна;
  - 2.7 Гуравдугаар циклийн хэрэглэгч нь төлбөрийн нэхэмжлэл [www.eus.mn](http://www.eus.mn) сайтад байрснаас хойш 7 хоногийн дотор буюу сар бүрийн 28-ны дотор усны төлбөрөө бүрэн төлсөн байна;
  - 2.8 Хэрэглэгч 2.7-д заасан хугацаанд усны үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд алданги тооцож эхэлсэн тухай мессежийг илгээх бөгөөд Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дэх хэсэгт заасны дагуу алдангийг хоног тутамд төлөгдөөгүй мөнгөн дүнгийн 0.2 хувиар тооцно;
  - 2.9 Хэрэглэгч усны үйлчилгээний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд буюу 3 ба түүнээс дээш сарын хугацаанд төлөөгүй тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр 29-ний өдрөөс ус хангамжийг хязгаарлах арга хэмжээг авна;
  - 2.10 Хэрэглэгч нь усны үйлчилгээний төлбөрийн улмаас ус хангамжийг хязгаарлуулсан тохиолдолд усны үйлчилгээний төлбөрөө бүрэн төлөх мөн ус хаалгаж, нээлгэсний төлбөрийг төлж, өр авлагын тооцоогүй болсон тохиолдолд хангагч ус хангамжийг нээж протокол хөтөлнө;
  - 2.11 Жилд 3-аас дээш удаа дээрхи төрлийн протокол хөтлөгдсөн хэрэглэгч нь найдваргүй хэрэглэгчийн бүртгэлд бүртгэгдэж гэрээ цуцлах төлөвт шилжих бөгөөд гэрээ цуцлах тухай мэдэгдлийг 2 сарын өмнө хэрэглэгчид албан ёсоор мэдэгдэнэ;
  - 2.12 Хангагч нь тухайн сарын усны үйлчилгээний төлбөртэй холбоотой мессежийг хэрэглэгч рүү илгээх бөгөөд төлбөр нь усны төлбөрийн нэхэмжлэл дээр нэмж тооцогдоно;
  - 2.13 Тоолуур, тооцооны хэмжих хэрэгслийн эвдрэл гэмтэл нь хэрэглэгчээс шалтгаалаагүй, эсхүл тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлаж, баталгаажуулах зорилгоор шугамаас салгасан бол өмнөх 3 сард хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээний дунджаар тооцон зөвхөн 1 сар тооцоо хийнэ;

#### ГУРАВ. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Хангагч нь хүн амын унд-ахуйн стандартад тохирсон цэвэр усаар хэрэглэгчийг тасралтгүй найдвартай хангаж, MNS 6561-2015 стандартын шаардлагыг хангасан бохир усыг төвийн шугамд хүлээн авч татан зайлуулна;
- 3.2 Хангагч нь төвийн цэвэр усны шугамын даралтыг 2.0 ата-аас багагүй байлгана;
- 3.3 Усны тоолуурын найдвартай ажиллагааг хангах зорилгоор усны тоолуур суурилуулах, баталгаажуулах, шалгах, засварлах зэрэг үйлчилгээ үзүүлнэ;
- 3.4 Хангагч нь хэрэглэгчийн тооцоо, судалгаа, саналыг үндэслэн бусад хэрэглэгчийг цэвэр, бохир усны шугамд холбох;
- 3.5 Хэрэглэгчийн усны тоолуурт тооцогдоогүй хэрэглэсэн цэвэр, бохир усны хэрэглээг нөхөн тооцох, төлбөрийг нэхэмжлэх;
- 3.6 Хангагчийн үйл ажиллагаатай холбоотой хэрэгцээтэй мэдээллээр хангах;
- 3.7 Хангагч нь үйлдвэрлэл явуулж буй хэрэглэгчийн нийлүүлж буй технологийн

- бохир уснаас сар бүр дээж авах;
- 3.8 Хангагчийн эрх бүхий ажилтнууд нь ажлын шаардлагаар хэрэглэгчийн ус хангамжийн хэмнэлттэй, найдвартай ажиллагаа болон төлбөр тооцооны хэрэгслийн хэвийн байдалд үзлэг шалгалт хийх, мөн түүнчлэн хэрэглэгчийн цэвэр, бохир усны шугам, тоног төхөөрөмж нь технологи ажиллагааны шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор барилга байгууламжид хэрэглэгчийн холбогдох албан тушаалтныг байлцуулан нэвтрэх;
- 3.9 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хэрэглэгчээс шаардах, албан шаардлага, мэдэгдэх хуудас өгөх, төлбөр нэхэмжлэх, гэрээ цуцлах, цэвэр усны хангамжийг хязгаарлах, шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 3.10 Төлбөр тооцооны хэмжих хэрэгсэл түүний битүүмжлэл, лац, холболтыг дураар өөрчилж, хэвийн ажиллагааг алдагдуулсан, зохих зөвшөөрөлгүйгээр, дур мэдэн өөр хэрэглэгчийг цэвэр усаар хангасан, хангагчийн эрх бүхий ажилтныг өөрийн барилга байгууламжид нэвтрэх боломж олгоогүй, хэвийн ажиллагааг алдагдуулах үйлдэл гаргасан зэргээс шалтгаалан тухайн зөрчил гаргасан хэрэглэгчийн цэвэр усны хэрэглээг хязгаарлах;
- 3.11 Хэрэглэгчээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шуурхай барагдуулах;
- 3.12 Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи болон бусад хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;
- 3.13 Хангагч нь төв шугамын төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус таслалтын тухай хэрэглэгчид дараахь байдлаар мэдээлэх; Үүнд:
- 3.13.1 Хангагч нь төв шугамын туршилт, ээлжит засварын ажлыг эрх бүхий байгууллагын баталсан графикайн дагуу явуулах бөгөөд уг төлөвлөгөөт таслалтын хугацааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд урьдчилан мэдээлэх;
- 3.13.2 Хангагч нь хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмжид хийх шаардлагатай засвар үйлчилгээний талаар зөвлөмж болон шаардах хуудас, албан бичгийг гэмтэл гарсан үед нь тухай бүр хэрэглэгчид өгч, засвар үйлчилгээний гүйцэтгэлд нь батлагдсан графикт зогсолттой уялдуулан хяналт тавих;
- 3.14 Хэрэглэгчийн гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хүсэлтийг үндэслэн тухай бүрд нь тодотголоор үндсэн гэрээний эх хувьд нь өөрчлөлт оруулж шийдвэрлэх;
- 3.15 Цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр хураамжид өөрчлөлт орвол мөрдөж эхлэхээс 15 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслэл болон өөрийн вэб сайтаар мэдээлж байх;
- 3.16 Дундын эзэмшлийн шугам сүлжээний засвар, үйлчилгээний зардлыг тухайн хэрэглэгчдийн хэрэглэсэн усны хоногийн дундаж хэрэглээг тооцон хуваарилах бөгөөд шугам сүлжээний заагийг нарийвчлан тогтоож гэрээнд хавсралтаар оруулсан байна.

#### ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Хэрэглэгч нь хүн амын унд-ахуйн стандартад тохирсон цэвэр усаар

- хангуулах, MNS 6561-2015 стандартын шаардлага хангасан бохир усыг төвийн шугамд нийлүүлэх;
- 4.2 Хангагчийн үйл ажиллагааны талаар холбогдох дээд байгууллагад мэдээлэх, санал хүсэлт, өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх;
  - 4.3 Гэрээ байгуулахаас өмнө хэрэглэгч усны тоолуурыг цэвэр усны шугамын оруулга дээр суурилуулсан байх ба тоолуурын зангилаа, түүний бүрэн бүтэн байдал, ашиглалт засвар үйлчилгээг хариуцах;
  - 4.4 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрлөөр холболт хийх, холболтыг эрх бүхий ажилтны хяналтан дор гүйцэтгэх;
  - 4.5 Хэрэглэгч нь хангагчийн эрх бүхий ажилтнуудыг цэвэр, бохир усны шугам сүлжээ, усны тоолуурын зангилаа зэргийг шалгах, заавар зөвлөгөө өгөх нөхцөл бололцоогоор бүрэн хангаж, ажлын үнэмлэхийг үндэслэн саадгүй нэвтрүүлэх;
  - 4.6 Хэрэглэгчийн усны тоолуур нь эвдэрсэн тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэж, 5 хоногийн дотор хэвийн ажиллагаанд оруулах;
  - 4.7 Хэрэглэгчийн цэвэр, бохир усны шугам нь дундын эзэмшлийн шугамтай холбогдсон бол уг шугамын засвар үйлчилгээг бусад хэрэглэгчидтэй хамтран гүйцэтгэх;
  - 4.8 "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15.1.9-д зааснаар хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, бололцоогүй бол хангагчаар хийлгэж, гарсан зардлыг төлөх;
  - 4.9 Хэрэглэгч нь усны тоолуурт Стандарт хэмжил зүйн газрын улсын шалгагчийн тавьсан тохируулгын, хангагчаас тавьсан хяналтын лац битүүмжлэлийг хариуцахаас гадна тоолуурын байрлал, холболтыг дур мэдэн өөрчлөхгүй байх;
  - 4.10 Хэрэглэгч нь технологийн хэрэглээнээс гарсан бохир усыг төв коллекторт нийлүүлэхдээ бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг баримтална;
  - 4.11 Хэрэглэгч нь өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох, өөрчлөгдөх бүрт [www.eus.us.mn](http://www.eus.us.mn) сайт руу нэвтэрч өөрчлөлтийг хийх;
  - 4.12 Хэрэглэгч нь НӨАТ төлөгч бол Улсын бүртгэлийн гэрчилгээний нэр, НӨАТ төлөгчийн нэр, гэрээ байгуулагчийн нэр ижил байна;
  - 4.13 Хэрэглэгч нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.10 заалт, хангагчаас олгосон техникийн нөхцөл, зөвшөөрөл, батлагдсан зураг төслийн дагуу өөрийн эзэмшлийн шугамаас бусад хэрэглэгчийг холбуулах үүрэгтэй;
  - 4.14 Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи болон бусад хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;
  - 4.15 Хэрэглэгч нь энэхүү гэрээний нэмэлт заалтанд тусгагдсан үүргийг гэрээний нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээнэ;
  - 4.16 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цэвэр усны шугамын алдагдал, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хангагчийн тогтоосон хугацаанд засварлах;
  - 4.17 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан үүргийг хүлээнэ;
  - 4.18 Хэрэглэгч нь 6 ба түүнээс дээш сарын хугацаанд ус ашиглахгүй тохиолдолд энэ талаар хангагчид албан бичгээр хандаж тухайн хугацаанд усны суурь хураамжаас чөлөөлөгдөнө;
  - 4.19 Хэрэглэгч нь төвийн цэвэр усны 2.0 ата даралтыг өөрийн хэрэгцээт даралт болгон өргөж ажиллуулах;

- 4.20 Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшлийн цэвэр, бохир усны шугам, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, шугам тоноглол, барилга байгууламжид ус алдагдахаас сэргийлэн, техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллахаас гадна суурилагдсан тоног төхөөрөмжийн тохируулга, хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдал ба хэвийн ажиллагааг хангах;
- 4.21 Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшил бүхий шугам, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэмтэл саатал гарвал хангагчид нэн даруй мэдэгдэж, цэвэр ус дамжуулах болон түгээх шугам дээр хаалгах арга хэмжээ авах, аюулгүй, найдвартай ажиллагааг хангах;
- 4.22 Хангагчаас өгсөн зөвлөмж, тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас өөрийн буруутай үйл ажиллагаанаас шугам, тоноглолд гэмтэл гарч, бусад хэрэглэгчдэд хохирол учруулбал уг хохирлыг хариуцаж барагдуулах;
- 4.23 Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтад орсон төсвөөс санхүүждэг эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага нь хэрэглээнээс гарсан бохир уснаас улирал бүр дээж авч, хангагч байгууллагын Усны төв лабораториор шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулна;

#### ТАВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Хэрэглэгч өөрийн буруутай үйл ажиллагаанаас өөрт болон бусдад учруулсан хохирлыг бүрэн хариуцна;
- 5.2 Өөрийн ашигладаг тоног төхөөрөмжинд засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс хангагч болон бусад хэрэглэгчийн ус хангамжийн үйл ажиллагаа саатсан, доголдсон бол гарсан хохирлыг хэрэглэгч бүрэн барагдуулна;
- 5.3 Хангагч нь өөрийн буруугаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэрэглэгчийн ус хангамжийг тасалдуулсан бол тэр хугацаанд ноогдох усны төлбөрөөс чөлөөлнө;
- 5.4 Хэрэглэгч нь зөвшөөрөлгүйгээр буюу зөвшөөрөлгүй цэгт бохир ус нийлүүлсэн тохиолдолд "Ус бохирдуулсны төлбөрийн тухай" хуулийн 10 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ;
- 5.5 Хэрэглэгч нь энэхүү гэрээний заалтуудыг зөрчсөн тохиолдолд "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 23 дугаар зүйлд заасан хариуцлагыг нэгэн адил хүлээнэ;

#### ЗУРГАА. ЦЭВЭР УСААР ХАНГАХ БА БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ, ЗОГСООХ НӨХЦЛҮҮД

- 6.1 Хангагч нь хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах ажиллагааг "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 16.2 дах хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хэсэгчлэн болон бүрэн зогсооно. Үүнээс гарах аливаа хохирлыг хангагч хариуцахгүй болно. Үүнд
  - 6.1.1 Хангагчтай байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн буюу гэрээний хугацаа дууссан зөрчил илэрсэн үед;
  - 6.1.2 Усны үйлчилгээний төлбөрийг 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар тогтоосон хугацаанд төлөөгүй;
  - 6.1.3 Хангагчийн зөвшөөрөлгүйгээр дамжин хэрэглэгчийг цэвэр усаар хангаж,

- бохир усыг татан зайлуулсан тохиолдолд;
- 6.1.4 Хангагчаас зохих зөвшөөрөл авсан дамжин хэрэглэгчийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбохоос үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд;
- 6.1.5 Хангагчийн эрх бүхий ажилтныг усны тоолуурын зангилаа, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид үзлэг шалгалт хийх, усны тоолуурын заалт авах, бохир усны дээж авч хэмжилт хийх, лац тавих, цэвэр усны горимын тооцоо хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэхэд санаатайгаар саад учруулсан тохиолдолд;
- 6.1.6 Тухайн хэрэглэгчийн эзэмшил дээрх ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн бүрэн бус байдлын талаар илэрсэн зөрчлийг арилгах шаардлагыг хүлээн авч биелүүлээгүй тохиолдолд;
- 6.2 Хангагч нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 16.1.1, 16.1.2, 16.1.3-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэглэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хязгаарлалт хийж болно;

**ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ГЭРЭЭ ДҮГНЭХ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ЦУЦЛАХ НӨХЦӨЛ**

- 7.1 Тус гэрээ байгуулсан өдрөөс эхлэн аль нэг талаас гэрээг цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө. /Энэхүү гэрээ нь анх 2012/05/29 -ны өдөр байгуулсан гэрээний үргэлжлэл болно/
- 7.2 Хангагч, хэрэглэгч нь жилд нэг удаа гэрээг дүгнэж, дараа жилийн цэвэр, бохир усны гэрээнд тодотгол хийнэ. /Энэхүү заалт нь гэрээ байгуулсан хугацаа болон хэрэглэгчийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарна/;
- 7.3 Хэрэглэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ 3 ба түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд цаашид гэрээг сунгах эсэх асуудлыг хангагчийн техникийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ;
- 7.4 Хэрэглэгч нь аж ахуйн гэрээний 4.13 заалтыг хангаж ажиллаагүй нөхцөлд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээ цуцлах арга хэмжээ авна;
- 7.5 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргасан тал нь 14 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. /Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ/;
- 7.6 Хэрэглэгч нь цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ 3 удаа биелүүлээгүй тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээг цуцлах арга хэмжээ авна;
- 7.7 Хангагч, хэрэглэгч нь аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдэлд хүрээгүй тохиолдолд шүүх, хууль хяналтын байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ;

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Хангагчийн талаас:  
ХҮА-ны дарга  
Гэрээний инженер



Хэрэглэгчийн талаас:  
( гарын үсэг)  
В. Доржсүх

## ГЭРЭЭ ХИЙХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэрэглэгчийн нэр **БАДМААНЯМБУУ.Ц**

Факс:

Емэйл:

Албантушаал:

Эзэн

**Ц БАДМААНЯМБУУ**

Угас:

99170336,96650337

Нягтлан

Менежер

Инженер

Бусад:

Улсын бүртгэлийн дугаар

Хэрэглэгчийн регистрийн дугаар **ЧИ57063001**

Хэрэглэгчийн НӨАТ төлөгчийн гэрчилгээний дугаар **0**

Шуудангийн хаяг

Хаяг: Улаанбаатар - 06 Хан-Уул - 3 -р хороо Үйлдвэрийн гудамж 100-1 тоот

Байршил: Улаанбаатар - 06 Хан-Уул - 3 -р хороо Үйлдвэрийн гудамж 100-1 тоот Говь ХК-ийн урд талд

Хэрэглэгчийн харьцдаг банк: **Банкгүй**

Дансны дугаар: **0**

**Үйл ажилгааны чиглэл:**

**Холболт:**

**Бусад мэдээлэл:**

|                       |                         |
|-----------------------|-------------------------|
| Төсөв:                |                         |
| Аж ахуй:              |                         |
| Орон сууц:            |                         |
| Үйлдвэр:              | Мах, махан бүтээгдэхүүн |
| Бохирдуулагч үйлдвэр: |                         |

|                     |                                     |
|---------------------|-------------------------------------|
| <b>Цэвэр ус:</b>    |                                     |
| Төвлөрсөн системээс | <input checked="" type="checkbox"/> |
| Гэр хорооллын шугам |                                     |
| Гүний худагтай      |                                     |
| Зөөврөөр            |                                     |
| Бусад               |                                     |
| <b>Бохир ус</b>     |                                     |
| Төвийн коллекторт   | <input checked="" type="checkbox"/> |
| Цооногтой           |                                     |
| Бохиргүй            |                                     |
| Бусад               |                                     |

|                          |   |
|--------------------------|---|
| Барилгын талбай м2       | 0 |
| Давхрын тоо              | 4 |
| Байрны тоо               | 1 |
| Ажиллах цаг              | 0 |
| Ажлын хоног              | 0 |
| Хүний тоо                | 0 |
| <b>Тоноглолуудын тоо</b> |   |
| Угаалтуур                | 4 |
| Суултуур                 | 4 |
| Банн                     | 0 |
| Писсаур                  | 0 |
| Шүршүүр                  | 1 |

**Тоолуурын тухай**

| Тоолуурын дугаар | Тоолуурын голч /мм/ | Тоолуурын оронгийн тоо | Гэрчилгээний дугаар | Тоолуурын төрөл | Марк  | Баталгаажсан огноо | Суурилуулсан огноо | Тоолуурын анхны заалт |
|------------------|---------------------|------------------------|---------------------|-----------------|-------|--------------------|--------------------|-----------------------|
| 002127           | 50                  | 7                      | 00168272            | Халуун          | WS-25 | 2020/03/05         | 2020/03/06         | 0                     |
| 009017           | 32                  | 5                      | 00168260            | Хүйтэн          | MTL   | 2020/03/05         | 2020/03/06         | 0                     |
|                  |                     |                        |                     |                 |       |                    |                    |                       |
|                  |                     |                        |                     |                 |       |                    |                    |                       |

Хэрэглэгчийн гэрээний дугаар **26049800**

Төлбөрийн дүнг мессежээр хүлээн авах угасны дугаар: **99170336**

Хэрэглэсэн усанд төлбөр тавих хугацаа:

Сар

Улирал

Гэрээний төрөл:

Байнгын

Түр

Гэрээ өөрчлөх болсон шалтгаан: **Гэрээ шинэчилсэн**

**Энэхүү хэсгийг УСУГ-ийн ажилтан бөглөнө.**

Техникийн нөхцлийн дугаар: **0**

Цэвэр усны цагирагийн дугаар: **79**

Худгийн тоо:

Бохир усны коллекторын дугаар: **Омнөдийн Ф1400**

Худгийн тоо:

Оруулга шугамын голч /мм-ээр/: **106**

*Ө. Дашням*

Ө.ДАШНЯМ

*Ц. Бадмаанямбуу*

Ц.БАДМААНЯМБУУ

хангагчийн гарын үсэг

тамга


хэрэглэгчийн гарын үсэг

Зааг эзэмшлийн зураг

Байгууллагын нэр: БАДМААНЫМБУУ.Ц

PRODUCED BY AN AUTODESK EDUCATIONAL PRODUCT

PRODUCED BY AN AUTODESK EDUCATIONAL PRODUCT




| Ус Сувгийн Удирдах Газар |                       |                | Он   | Тэмдэглэгээ |  |   |
|--------------------------|-----------------------|----------------|------|-------------|--|---|
|                          |                       |                | Сар  | Барилга     |  |   |
|                          |                       |                | Өдөр |             |  |   |
| Хянасан                  | <i>О. Хуучин</i>      | Ө.ДАШНЯМ       |      |             | Хэрэглэгчийн хариуцах цэвэр усны шугам |   |
| Тогтоосон                | <i>Т.Баасанхүү</i>    | Т.БААСАНХҮҮ    |      |             | Хэрэглэгчийн хариуцах бохир усны шугам |   |
| Зөвшөөрсөн               | <i>Ц.Бадмаанямбуу</i> | Ц.БАДМААНЫМБУУ |      |             | ЦУХ-ын тоо                             | 2 |
|                          |                       |                |      |             | БУХ-ын тоо                             | 4 |



БАТЛАВ:


“ТҮМЭН ЭГШИГ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
АССАЙРС” УЛААНБААТАР

  
Т.ЧИНЗОРИГ  
ТГГ1045-5031923

**ХИМИЙН БОДИСЫН ХАЯГДАЛ САВ БООДОЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

БАТЛАВ:

“АР СИ ИНСПЕКШН АЗИА  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
М.ГАНЧИМЭГ

2023 оны 05-р сарын 16-ны өдөр

№23/01

Улаанбаатар  
хот

Нэг талаас Монгол улс, Улаанбаатар-17011, Баянзүрх дүүрэг, 14-р хороо Намянжү-ын гудамж 44 байр, 205 тоотод байрлах “ТҮМЭН ЭГШИГ” ХХК (улсын бүртгэлийн дугаар: 9011053065, регистрийн дугаар: 5031923)-ийг төлөөлж менежер Б.Одбаяр цаашид “Хүлээн авагч” гэх, Нөгөө тал Монгол Улс, Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж 100/1 байр 3,4-р давхар (регистрийн дугаар: 5723612)-ийг төлөөлж Хүний нөөцийн менежер Ч.Дуламза цаашид “Шилжүүлэгч” гэх нар Шилжүүлэгчийн үйл ажиллагааны явцад гарсан химийн бодисуудын үлдэгдэл, суларсан хуванцар савнууд, шаазан тигелийг “ТҮМЭН ЭГШИГ” ХХК -ийн химийн бодисын хаягдлыг хадгалах байгууламжинд шилжүүлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг доорхи нөхцөлөөр байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Гэрээ байгуулагч талууд нь 2017 онд шинэчлэн батлагдсан “ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ” Монгол улсын хууль, холбогдох дүрэм, журмыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулсан ба үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 1.2. Шилжүүлэгчийн зүгээс Хүлээн авагчид энэхүү гэрээний хугацаанд химийн бодисын суларсан хуванцар, шил савнууд шаазан тигельнүүд химийн бодисын саармагжуулсан үлдэгдэл (цаашид “хог хаягдал” гэх) шилжүүлснээр Хүлээн авагч нь химийн бодисын хаягдлыг аюулгүй байгууламжид хадгалж, цаашид ахуйн эргэлтэн оруулахгүй байх үүрэг хүлээнэ.

### ХОЁР. ХҮЛЭЭН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Хүлээн авагч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль тогтоомж, тэр дундаа Монгол Улсын Цагаар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54 А/136/А/215 дугаар хамтарсан тушаалаар баталсан “ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АШИГЛАХ, УСТГАХ ЖУРАМ”-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 2.2 Хүлээн авагч нь химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахтай холбоотой холбогдох эрх байгууллагын зөвшөөрөл авсан байна.
- 2.3. Хүн ам оршин суугаа газраас 500-аас доошгүй метрийн зайд, үер усанд автахгааргүй байрлалтай, галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын

- үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цемент болон плит), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай агуулахад хадгална.
- 2.4. Химийн бодисын хаягдлыг агуулахад байршуулахаар Шилжүүлэгч талаас хүлээн авснаар тухайн хаягдлын хувьд бүхий л хариуцлагыг хүлээн авах үүрэгтэй.
- 2.5. Аюултай хаягдлыг өмчлөх эрх, хариуцлагыг шилжүүлэн авсан тухайгаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд албан бичгээр мэдэгдэж, аюултай хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ. Аюултай хаягдлыг өмчлөх эрх, хариуцлагыг шилжүүлэн авсан тухайгаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд албан бичгээр мэдэгдэж, аюултай хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ. Бүртгүүлсэн бүртгэлийн I хувийг шилжүүлэгч талд хүлээлгэн өгнө.
- 2.6. Устгасан тухай протоколыг шилжүүлэгч талд хүлээлгэн өгнө.
- 2.7. Аюултай хаягдал тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн, зориулалтын тээврийн хэрэгслээр хаягдлыг тээвэрлэнэ.
- 2.8. Химийн бодисын хор, аюулын талаархи лавлах мэдээлэл, тэдгээрийг тээвэрлэх болон хадгалах явцад гарч болзошгүй ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж сургалтыг зохион байгуулна.
- 2.9. Хүлээн авагч тал нь химийн бодисын хаягдлыг тээвэрлэх хэрэгсэлд ачих, өргөх болон түүн дээр ажиллах, ачааг буулгах ажлыг бүрэн хариуцна.
- 2.10. Химийн бодистой харьцаж ажиллагсдыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслээр хангана.
- 2.11. Шилжүүлэн авсан химийн бодисын хаягдлаас дээж авч түүнд анхан шатны шинжилгээ хийнэ.
- 2.12. Хүлээн авагчийн буруутай үйл ажиллагаанаас болж гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хүлээн авагч хохирлыг бүрэн хариуцаж төлж барагдуулах үүрэгтэй.

## **ГУРАВ. ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Монгол Улсын Шалар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54 А/136 А/215 дугаар хамтарсан тушаалаар баталсан **"ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АШИГЛАХ, УСТГАХ ЖУРАМ"**-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 3.2. Хадгалах хаягдлыг сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой бэлтгэнэ.
- 3.3. Үйлдвэрлэгчээс боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн боловсруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.
- 3.4. Болзошгүй аюул, ослын үед ашиглах зориулалтын, бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг ажлын байранд байрлуулах ба химийн бодистой харьцаж ажиллагсдыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслээр хангасан байна.
- 3.5. Хүлээлгэн өгөх химийн бодисын хаягдал, сав баглаа боодлыг жагсаалтын дагуу хүлээлгэн өгнө.

## ДОРӨВ, ТӨЛБӨР, ТООЦОО

- 4.1. Шилжүүлэгчийн хавсралтанд заагдсан төлбөрийн дагуу химийн бодисын хаягдлыг хадгалахаар харилцан тохиролцов. Үүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад зардал багтсан болно.
- 4.2. Энэхүү гэрээний дагуу Шилжүүлэгчээс Хүлээн авагчид төлөх төлбөрийг химийн хаягдлыг ачиж авч явсан өдөр нь ХХБ банкны 499085408 тоот дансанд шилжүүлнэ. Гэрээнд заасан төлбөрийг хуваарьт хугацаанаас хожимдуулсан тохиолдолд хоногийн 0,1 хувийн алданги тооцно.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

- 5.1. Энэхүү гэрээ нь 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг сунгах, эсвэл цуцлах саналаа албан бичгээр илэрхийлнэ.
- 5.3. Шилжүүлэгч талаас урьдчилж гаргасан хүсэлт, захиалгын дагуу химийн бодисын сав боодлыг ачиж тээвэрлэх хугацааг тогтоож гүйцэтгэнэ.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1. Хүлээн авагч тал нь энэхүү гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэх явцад зохих ёсоор гүйцэтгээгүй, эсвэл үүргийг зөрчсөн, аюулгүй байдлыг хангаагүйгээс Шилжүүлэгч тал, түүний ажилтан, гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд Талууд энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарсан бүх маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 6.2. Маргааныг хэлэлцээрээр шийдвэрлэж чадахгүй нөхцөлд хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Талуудын хүсэл, зоригийн гадуур, урьдчилан мэдэж арилгах боломжгүй дайн байлдаан, иргэдийн бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөлт, бүслэлт, хориг, газар хөдлөлт, усны үер, гал түймэр, бусад байгалийн аюулт үзэгдэл зэрэг нөхцөл байдлын улмаас гэрээг биелүүлэх боломжгүй болсон бол гэрээний оролцогчид харилцан хариуцлага хүлээхгүй.

## НАЙМ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- 8.1. Шилжүүлэгч нь Хүлээн авагчийг ажил үүргээ эхлэхийн өмнө гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч Байгаль орчны болон Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг танилцуулна.
- 8.2. Хүлээн авагч нь өөрийн ажиллагсдын аюулгүй байдлыг хариуцах хүнийг томилох, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, багаж, тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагаа, учирч болох эрсдлүүд, тэдгээрээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 8.3. Хүлээн авагч нь гэрээт ажил үүргийг гүйцэтгэх хугацааны туршид Шилжүүлэгчийн аюулгүй ажиллагааны болон галын аюулгүй байдал, Байгаль орчны хяналтын дүрэм журмыг баримтлан ажиллах бөгөөд түүнтэй холбогдон гарах, бүхий л асуудлыг өөрөө бүрэн хариуцна.

- 8.4. Хүлээн авагч нь тухайн ажилд ашиглагдаж байгаа материалын хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцан ажиллах бөгөөд тухайн ажлаас гарсан хаягдлыг хууль, журмын дагуу устгах, хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэж буй эсэхээ хянаж ажиллана.
- 8.5. Хүлээн авагч нь хэрэв аюултай бодис хэрэглэж байгаа бол урьдчилан эрх бүхий байгууллагаас хэрэглэх зөвшөөрөл авсан байх, аюултай бодис асгарч гоожихоос хамгаалах төхөөрөмжтэй байх шаардлагатай.
- 8.6. Тусгай зөвшөөрөлтэй ажиллах ажил үүрэг гүйцэтгүүлэх тохиолдолд эрх бүхий байгууллагаас авсан зөвшөөрлийн баталгаажсан бичиг баримтыг гэрээнд хавсаргаж оруулна.
- 8.7. Хүлээн авагч нь үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах бөгөөд гарсан ослын талаар Шилжүүлэгч талд болон мэргэжлийн байгууллагад үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.
- 8.8. Хэрэв тухайн гүйцэтгэж буй ажил нь Шилжүүлэгч талын, эсвэл Хүлээн авагч талын ажиллагсдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах нөхцөл үүссэн бол Шилжүүлэгч тал ажлыг зогсоох, гэрээг цуцлах эрхтэй.

### ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Гэрээг дагалдах хавсралтын хамт 3 хувь үйлдэн талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.




“АР СИ ИНСПЕКШН АЗИА АССАЙРС” ХХК

Хүний нөөцийн менежер Ц.ДУЛМАА

**"ТҮМЭН ЭГШИГ" ХХК-ийн химийн бодисын хаягдлыг тээвэрлэж хадгалах үнийн санал.**

| # | Бараа материал, үйлчилгээ                        | Тоо хэмжээ   | Тайлбар   |
|---|--|--|---|
| 1 | Химийн бодисын хаягдлыг тээвэрлэх, хадгалах ажил | Нийт 4 төрлийн 200 кг химийн хаягдлыг тээвэрлэж хадгална.<br>Нийт зардал 1 100 000 төгрөг /НӨАТ-тэй/ | <ul style="list-style-type: none"> <li>•Төлбөрийг компанийн ХХБ банкны 499085408 дансанд шилжүүлнэ.</li> <li>• Ажил гүйцэтгэх хугацааг ажлын нэг өдөрт багтаана</li> <li>• Ажил эхлэх хугацааг урьдчилан тохиролцоно</li> </ul> |

**Нийт зардлын задаргаа /хаягдлын төрөл нэг бүрээр/**

| № | Хуванцар савны төрөл                    | Хуванцар савны гадаад байдал  | Тоо ширхэг      | Үнийн санал, төгрөг |
|---|---|---|-----------------|---------------------|
| 1 | Шаазан тигель.                          | Том шмат<br>Жижиг капель  | 500 ш<br>500 ш  |                     |
| 2 | 22л-ийн багтаамжтай хуванцар сав        |  | 3-5 ш           |                     |
| 3 | Лабораторийн химийн урвалжуудын хаягдал | ойролцоогоор  | 35-50 л         |                     |
| 4 |   | Хүчлийн 0.5 л хуванцар сав  | 20-35 ш         |                     |
|   |   | Шилэн хаягдал ойролцоогоор  | 1 кг            |                     |
|   |   | <b>Шлаг</b>   | <b>50-80 кг</b> |                     |
|   | Нийт дүн                                |   |                 |                     |

БАТЛАВ.

БАТЛАВ.

ХУД-ийн "ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ

Өсөхтүрүү ХХК

ТӨВ" ОНӨААТҮГ-ын  
ЗАХИРАЛ

Ц.ЭРДЭНЭБААТАР

ЗАХИРАЛ

/Захиалагч ААН, байгууллага/  
Бадмаанямбуу

### ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 05 сарын 17

№23-05/17

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас Хан-Уул дүүргийн "Тохижилт үйлчилгээний Төв" ОНӨААТҮГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, Нөгөө талаас **5100933** тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах, **Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл ХХК** чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг **Өсөхтүрүү ХХК** /цаашид Захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь **2023 оны 05 сарын 17-ны өдрөөс 2024 оны 05 сарын 16-ны өдөр** хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн хүрээнд ХУД-ийн нутаг дэвсгэрийн орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, мөн нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын **2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45** дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.
- 1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн **2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29** тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.
- 2.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна.
- 2.3 Айл өрхөөс гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлын төлбөрийг төлүүлсний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.
- 2.5 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг ААН, байгууллага болон иргэд, захиалагч байгууллагуудаас шаардах эрхтэй.
- 2.6 Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.

## 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Тухайн ААН, байгууллага, барилга байгууламжаас гарсан хог хаягдлыг зөвхөн тогтоосон хогийн цэг буюу бункерт хийж ачуулах үүрэгтэй.
- 3.2 Тухайн ААН, байгууллага өөрийн талбай /хашаа/-аас гадагш \_\_\_\_\_ зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг байнга хийж гарах хог хаягдлыг тээвэрлүүлж байна.
- 3.3 Захиалагч тал нь тэрээний 3.2-д заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.4 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 25 -нд Улаанбаатар банкны Хог хаягдал үйлчилгээний хураамжийн **2603033364** тоот /Хүлээн авагч: ХУД. Хог хаягдлын хураамж/ дансанд тушаана.
- 3.5 ААН, байгууллагын барилга байгууламжид засвар хийсэнтэй холбогдон гарсан барилгын болон бусад хог хаягдлыг тухай бүрд нь дуудлага өгч буюу захиалгаар тээвэрлүүлэх үүрэг хүлээх бөгөөд хогны хэмжээнээс хамааран нэмэлт төлбөр төлж хариуцсан албан тушаалтантай хамтарч ажиллана.
- 3.6 Хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулж, машин чөлөөтэй орж гарах нөхцөлийг хангана.
- 3.7 Хогийн сав, бункерийн орчимд машин тэрэг тавиулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.8 Өөрийн эзэмшил, өмчлөлийн барилгаа барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар гүйцэтгэгч талтай урьдчилан гэрээ байгуулан зохих төлбөрийг төлнө.
- 3.9 Хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.10 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.
- 3.11 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.12 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.
- 3.13 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.14 Дүүрэг болон бусад байгууллага, албан тушаалтнаас зарласан уралдаан, аянд идэвхитэй оролцож тодорхой үр дүн үзүүлсэн бол шагнал урамшуулал хүртэх эрхтэй.
- 3.15 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 3.16 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

### Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 4.1 Гэрээт хугацаанд **Сард 3 удаа** иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь ХУД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард \_\_\_\_\_ улиралд \_\_\_\_\_, жилд \_\_\_\_\_ төгрөг байна.
- 4.3 Тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу Орон сууц, ААН, хувь хүний захиалгаар хог тээвэрлэлт хийхэд гарах төлбөр:

|                               |                        |                     |
|-------------------------------|------------------------|---------------------|
| 8 тн шахдаг автомашин         | - Ахуйн хог хаягдал    | - 150,000.00 төгрөг |
| 4 тн шахдаг авто машин        | - Ахуйн хог хаягдал    | - 85,000.00 төгрөг  |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Ахуйн хог хаягдал    | - 85,000.00 төгрөг  |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Барилгын хог хаягдал | - 95,000.00 төгрөг  |

- 4.4 “Хог хаягдлын тухай” хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт болон зах зээлийн үнийн интервалаас хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.
- 4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.
- 4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.4-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

#### Тав. Хамтран хүлээх хариуцлага

- 5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.
- 5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 5.3 Нийслэл дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

#### Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

- 6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.
- 6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

#### Долоо. Бусад

- 7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

#### Найм. Нэмэлт өөрчлөлт

20 ..... оны ..... сарын ..... –ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

.....

.....

.....



Ес. Гэрээний сунгалт

9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

9.1.2 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

9.1.3 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Арав. Гэрээ байгуулсан талууд

Гүйцэтгэгч тал  
ХУД-ийн "Тохижилт Үйлчилгээний Төв"  
ОНӨААТҮГ-ын ХТҮХ-ийн Хороо хариуцсан  
хяналтын ажилтан  
албан тушаалтай / Д.Сумъяадорж /  
Гарын үсэг: \_\_\_\_\_  
Утас: 95871256  
Хог тээвэрлэлтийн захиалга өгөх, санал гомдлын  
Утас: 96613002 / ХТҮХ-ийн дарга  
Г.Бадамсэд/

Захиалагч тал  
Өсөхтүрүү ХХК-н  
Захирал  
албан тушаалтай / Бадмаанямбуу /  
Гарын үсэг: \_\_\_\_\_  
Утас: 99170336  
Хаяг: Ланд дрийлийн хойд талд 4 давхар  
хүрэн судалтай шар байшин